Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн иргэдийн эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, хандлагыг үнэлэх

Л.Нандинцэцэг[1], Б.Цэрэнлхам[1], Г.Дөлгөөн[1], Б.Мягмарсүрэн[1], С.Мөнхбат[1]

[1]АШУҮИС, Эм Зүйн Сургууль
Цахим шуудан: nandintsetseglhagva@gmail.com, Утас:99845325

Түлхүүр үг:

Цаасан хэлбэрийн асуумж судалгаа
Цахим судалгаа

Товч утга: Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн иргэдийн эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, хандлагыг үнэлэхээр цахим (Google form платформыг ашиглан) болон цаасан хэлбэрээр асуумж судалгаа явуулсан. Ингэхдээ цахим судалгаанд нийт 1444 иргэд, цаасан судалгаанд нийт 1977 иргэдийг тус тус оролцуулан 4 бүлэг бүхий 40 асуумжийг судалгаанд оролцогчдын зөвшөөрлийн дагуу цуглуулсан. Үүнээс цахим судалгаанд нийт оролцогдын 717 буюу 49.65% нь эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг хангалттай, 716 буюу 49.58% нь эмэнд хандах хандлага зохистой байсан бол харин цаасан хэлбэрээр явуулсан судалгаанд нийт оролцогчдын 673 буюу 34.04% нь эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг хангалттай, 407 буюу 20.59% нь эмэнд хандах хандлага зохистой байв. Мэдээлэл хүлээн авч буй хэрэгслийн хувьд хэвлэл мэдээлэл, цахим орчин, найз нөхдөөсөө мэдээлэл авч буй иргэдийн эзлэх хувь харьцангуй өндөр байв. Судалгаанд оролцогчдын эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэгийн ялгаатай байдал нь боловсролын түвшин, өрхийн орлого, оршин сууж буй газар зэрэгт статистик ач холбогдол бүхий ялгаатай гарсан бол эмээ мартсан тохиолдолд дараагийн эмтэйгээ давхарлан уух зохисгүй хэрэглээний хандлага гаргадаг байна.

Үндэслэл: Эмийн зохистой хэрэглээ гэдэг нь хэрэглэгчдэд тохирсон эмийг, тохирсон тунгаар, тохирох хугацаанд, хамгийн бага зардлаар, эмнэлзүйн нөхцөлд тохируулан хэрэглэхийг хэлдэг[1].

ДЭМБ-ийн тодорхойлсноор эмийн зохистой хэрэглээний талаарх олон нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулах нь эмийн зохистой хэрэглээг дэлгэрүүлэх үндсэн арга юм. Олон улс орнуудад бүх өвчлөлийн 80 орчим хувьд иргэд дур мэдэн эмчилгээ хийдэг гэсэн тоо баримт гарсан байна. Дийлэнх тохиолдолд хэрэглэгч өөрөө эмийн сонголтыг хийдэг бөгөөд энэхүү сонголтод маш олон хүчин зүйлүүд нөлөөлдөг. Үүнд: гэр бүл, найз нөхдийн туршлага, өөрсдийн итгэл үнэмшил, эм үйлдвэрлэгч, эмнэлэгийн ажилтны заавар зөвлөгөө багтдаг[2].

Манай орны хувьд эмч нарын эмийн жор бичилт хангалтгүй, эмийн сангууд антибиотик эмийг жоргүй олгох үзэгдэл түгээмэл байдагтай уялдан хүн амын дунд антибиотикийн зохистой хэрэглээний ойлголт хандлага төлөвшөөгүй, антибиотикийг эмчийн жоргүй дур мэдэн худалдан авч хэрэглэдэг зан үйлийн буруу дадал байсаар байгаа тухай нэлээд олон судалгаа хийгдсэн байдаг. Харин үйлчлүүлэгчийн эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, хандлагыг үнэлэн түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох судалгаа бага байгаа нь энэхүү судалгааг хэрэгжүүлэн үр дүнг нь шийдвэр гаргахад ашиглах үндэслэл болсон.

Зорилго: Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн хэрэглэгчдийн эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, хандлагыг үнэлэх явдал бөгөөд дараах зорилтуудыг дэвшүүллээ.


Зорилт:

1. Иргэдийн эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэгийг үнэлэх
2. Иргэдийн эмийн зохистой хэрэглээний талаарх хандлагыг үнэлэн, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох

Арга, аргачлал: Судалгааг эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, хандлага түүнд нөлөөлөх


хүчин зүйлсийг судлах зорилгоор хүн амд суурилсан, нэг агшингийн судалгааны загварыг ашиглан гүйцэтгэсэн. Цахим судалгаанд нийт Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн 1444 хүн хамрагдсан бол цаасан хэлбэрээр явуулсан судалгаанд нийт 1977 иргэд тус тус хамрагдсан. Оролцогчдоос асуумжийн аргаар эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, хандлагын талаар тусгайлан бэлтгэсэн 4 бүлэг 40 асуулт бүхий асуумжийг судалгаанд оролцогчдийн зөвшөөрлийн дагуу цуглуулсан.

Үр дүн: Цахим судалгааны нийт 1444 оролцогчийн 717 буюу 49.65% нь мэдлэг хангалттай байсан бол хандлагын хувьд 716 буюу 49.58% эмэнд хандах хандлага зохистой байв. Цаасан хэлбэрийн асуумж судалгаанд оролцогчдын 673 буюу 34.04% нь эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг хангалттай байсан бол 407 буюу 20.59% нь эмэнд хандах хандлага зохистой байв. (Зураг 1)



Зураг 1. Эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, хандлага

Зураг 2-т эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг хангалттай болон хангалтгүй бүлгийн зар сурталчилгаагаар зонхилон сурталчилдаг эмийг илүү үр дүнтэй гэж үздэг эсэхийг тодруулахад эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг хангалтгүй бүлгийн оролцогчдын 12%, хангалттай мэдлэг бүхий оролцогчдын 7% тийм гэж хариулсан бөгөөд дээрх ялгаатай байдал нь статистик ач холбогдол бүхий байна (p=0.0009).



Зураг 2. Зар сурталчилгаагаар зонхилон сурталчилдаг эмийг илүү үр дүнтэй гэж үздэг байдал

Мэдлэгийн түвшинг амьдарч буй байршлаар авч үзэхэд аймгийн төв болон сумын иргэдийн мэдлэгийн түвшин хотын иргэдтэй харьцуулахад харьцангуй бага байна (p<0.001).

Хэлцэмж: Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн иргэдийн эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, хандлагыг үнэлж, харьцуулан судлахад иргэдийн мэдлэг болон хандлага 50% хүрэхгүй буюу хангалтгүй байсан бөгөөд ялангуяа хөдөө орон нутагт амьдарч буй иргэдийн мэдлэг харьцангуй бага байлаа. Энэхүү үр дүнг судлаач Б.Отгонбат нарын 2019 оны судалгаагаар нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн жор баригч нарын зөвлөгөө өгсөний дараа, эм хүлээж авсан үйлчлүүлэгчийн эмийн тун, зохистой хэрэглээний талаарх мэдлэг (61.6%) дүн, 2000 онд П.Нямсүрэн нарын “Эмийн зохистой хэрэглээний зарим судалгаа”-ны үр дүн (52.1%), 2009 оны “Монгол улсын эм зүйн салбарын үнэлгээ”-ний тайлангийн дүн (56.6%) зэргээс харьцангуй бага байгаа нь эмийн хэрэглээний талаар хүн амд олгох мэдээлэл, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа харьцангуй бага байгааг харуулж байна.[8]

ДЭМБ-ын зөвлөмжөөр жоронд бичигдсэн эмийнхээ талаар үйлчлүүлэгч 100%-ийн мэдлэг, мэдээлэлтэй байх ёстой ба бидний судалгааны үр дүнд 41.85% байгаа нь Пакистан (54.9%) улсаас 13.05%-аар, зүүн Эмират (61.8%) улсаас 19.95%-аар дутуу байна. Энэ нь хүн амд эмийн хэрэглээний талаар өгөх мэдээлэл, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хангалтгүй, мөн эмч болон эм зүйчээс үйлчлүүлэгчид өгч байгаа эмийн талаарх зөвлөгөө хангалтгүй байгааг харуулж байна.[43,60]

Дүгнэлт: Манай иргэдийн эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг 41.845%, хандлага 64.92% буюу хангалтгүй байна. Эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэгийн түвшин хангалтгүй байх нь хөдөө орон нутагт буюу аймгийн төв болон суманд харьцангуй их байх бөгөөд иргэдийн эмийн хэрэглээнд цахим орчин болон зар сурталчилгаа илүү нөлөөлж байна.

Талархал: Судалгаа хийхэд гүн туслалцаа үзүүлсэн АШУҮИС-н Эм Зүйн Сургуулийн Эмнэлзүйн Эм Зүй, Менежментийн тэнхимийн багш нар болон Эм, Эмнэлгийн Хэрэглийн Хяналт, Зохицуулалтын Газрын хамт олон болон судалгаанд идэвхтэй оролцсон иргэдэдээ баярлаж талархснаа илэрхийлье.

Ном зүй:

1. *World Health Organization The rational use of drugs; Conference of Experts Nairobi; 25-29 November 1985; Geneva: Accessed February 1, 2022*
2. *ДЭМБ 1997*
3. *WHO. Дэлхийн эрүүл мэндийн статистик: Мэдээллийн эх үүсвэр:http://www.who.int/gho/publications/world_health_statistics/ Accessed January 11, 2022*
4. *ДЭМБ, Эрүүл мэндийн судалгааны арга зүй .Улаанбаатар 2011. Х.34-40*
5. *Cross-Sectional Survey among General Population Regarding Knowledge and Attitude toward Antibiotic Usage in Western Saudi Arabia. Accessed January 2, 2022*
6. *A population-base survey on knowledge,attitude and awareness of the general public on antibiotic use and resistance. Accessed February 2, 2022*
7. *Antibiotic knowledge, attitudes and practices: new insights from cross-sectional rural health behaviour surveys in low-income and middle-income South-East Asia. Accessed February 15, 2022*
8. *Б.Отгонбат, Б.Булган, Ч.Ерөөлт, Д.Энхжаргал. Жорын үзүүлэлтүүд ба эмийн талаарх үйлчлүүлэгсдийн мэдлэгийг үнэлсэн судалгааны дүн. Innovation сэтгүүл, Vol 12. №1. 2018.*

Assess the knowledge, skills and attitudes of Ulaanbaatar and Rural residents about rational usage of drug

Nandintsetseg L[1], Tserenlkham B[1], Dulguun G[1], Myagmarsuren B[1], Munkhbat S[1]

[1]School of Pharmacy, MNUMS
E-mail: nandintsetseglhagva@gmail.com, Tel: 99845325

Background: An online and paper survey was conducted to assess the knowledge, skills, and attitudes of Ulaanbaatar and Rural residents about rational use of drug. A total of 40 questionnaires in 4 groups were collected with the permission of the survey participants, including a total of 1444 citizens in the electronic survey and a total of 1977 citizens in the paper survey.
Aim: Assess the knowledge, skills and attitudes of Ulaanbaatar and Rural residents about rational usage of drug.
Materials and Methods: The survey was conducted using a population-based, one-moment survey model to assess the knowledge, skills, and attitudes of Ulaanbaatar citizens about the rational usage of drug.
Results: In the e-survey, 717 or 49.65% of the participants had sufficient knowledge about rational usage of drug, while 716 or 49.58% had a positive attitude towards drugs. In the paper survey, 673 or 34.04% of the participants had sufficient knowledge about rational usage of drug, while 407 or 20.59% had a positive attitude towards drug.
Conclusions: A less than 50% of the total participants in the survey doesn't have an enough knowledge and attitude about the rational usage of drug.

Keywords: online survey, paper survey